



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 2/80

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын үйл ажиллагааг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлийн 10.3, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2011 оны А/122, А/359, 2012 оны А/217, 2015 оны А/261, 2016 оны А/278 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сахуу татрангийн эсрэг вакцины хуваарийг нэгдүгээр, вакцины зааврыг хоёрдугаар, дархлаажуулалтын хамралтын мэдээний хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт дараах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1.Үндэсний дархлаажуулалтын товллын дагуу сахуу, татрангийн эсрэг вакцинаар 7, 15 настай хүүхдийг байнгын болон түр цэгээр дархлаажуулах ажлыг зохион байгуулах,

2.2.Заавал хийх товллын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтад хамруулах,

2.3.Улирлын томуугийн эсрэг вакцинаар жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-5 насны хүүхдийг дархлаажуулах ажлыг эрчимжүүлэх,

2.4.Өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын байнгын болон явуулын цэгийн урсгал зохион байгуулалт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах, мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулах,

2.5.Дархлаажуулалтын үеэр вакцины хүйтэн хэлхээ, аюулгүй дархлаажуулалтын холбогдох тушаал, зааврыг нягт баримталж, хяналт тавих, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтыг эрчимжүүлэн, бүртгэгдсэн тохиолдлыг цаг хугацаанд нь мэдээлэх, тандан судлах, хариу арга хэмжээ авах,

1704292091

2.6.Дархлаажуулалтын хамралтын мэдээг хүснэгтийн дагуу өдөр бүр 16:30 цагт дархлаажуулалт хариуцсан тархвар судлаачид ирүүлэх

3.Дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган, дархлаажуулалтыг хийхэд шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийг татан авч дархлаажуулалтын цэгүүдийг ханган, хамралтын мэдээг гаргаж ажиллахыг дархлаажуулалт хариуцсан Тархвар судлаач (Ө.Ариунжаргал)-д даалгасугай.

4.Дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд өргөнөөр Нийгмийн эрүүл эрүүл мэндийн мэргэжилтэн (Д.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.


5.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга (Т.Энх-Амгалан)-д даалгасугай.

ДАРГА



А.СУВДАА

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн  
 №80 дугаар тушаалын 1-р хавсралт




САХУУ ТАТРАНГИЙН ЭСРЭГ ВАКЦИН,  
 ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

| №   | Өрхийн эрүүл мэндийн төвийн нэрс | Хороо | Статистик тоо |           |       | Шаардлагатай вакцин, тариур |                |
|-----|----------------------------------|-------|---------------|-----------|-------|-----------------------------|----------------|
|     |                                  |       | 7 настай      | 15 настай | Нийт  | Олгох хүн тун /4 цэнт/      | Тариур 1 мл, ш |
| 1.  | Мөнхбадрах өрх                   | 1     | 279           | 216       | 495   | 360                         | 360            |
| 2.  | Тэрмэстий                        | 2     | 340           | 249       | 589   | 420                         | 420            |
| 3.  | Энхтитэм                         | 3     | 510           | 216       | 726   | 520                         | 520            |
| 4.  | Цэц до-4                         | 4     | 150           | 89        | 239   | 170                         | 170            |
| 5.  | Цэц до-23                        | 23    | 299           | 145       | 444   | 320                         | 320            |
| 6.  | Манал -Үйлс                      | 5     | 123           | 64        | 187   | 130                         | 130            |
| 7.  | Чанд авиа                        | 6     | 143           | 114       | 257   | 180                         | 180            |
| 8.  | Хашчагнуур                       | 7     | 101           | 68        | 169   | 120                         | 120            |
| 9.  | Уясах                            | 8     | 287           | 160       | 447   | 320                         | 320            |
| 10. | Аяут                             | 9     | 198           | 141       | 339   | 240                         | 240            |
| 11. | Аминтус                          | 10    | 263           | 181       | 444   | 320                         | 320            |
| 12. | Амгалан өрх-11                   | 11    | 289           | 235       | 524   | 380                         | 380            |
| 13. | Амгалан өрх-22                   | 22    | 221           | 142       | 363   | 260                         | 260            |
| 14. | Био асралт                       | 12    | 143           | 107       | 250   | 180                         | 180            |
| 15. | Туул тосгоны ЭМТ                 | 13    | 70            | 65        | 135   | 100                         | 100            |
| 16. | Энх амгалан өлзийт               | 14    | 132           | 110       | 242   | 180                         | 180            |
| 17. | Мэндсаруул өрх 15                | 15    | 506           | 351       | 857   | 620                         | 620            |
| 18. | Мэндсаруул өрх 18                | 18    | 385           | 240       | 625   | 450                         | 450            |
| 19. | Мэндсаруул өрх 19                | 19    | 460           | 292       | 752   | 540                         | 540            |
| 20. | Энхбуянтманал                    | 16    | 213           | 137       | 350   | 250                         | 250            |
| 21. | Амгалан Оргил өрх                | 17    | 389           | 298       | 687   | 500                         | 500            |
| 22. | Нинж Ундарга эх                  | 20    | 315           | 160       | 475   | 340                         | 340            |
| 23. | Дуут жинст                       | 21    | 392           | 192       | 584   | 420                         | 420            |
| 24. | Эрдэнэ энхсаран                  | 24    | 437           | 182       | 619   | 440                         | 440            |
| 25. | Степпе хэйлт                     | 25    | 234           | 122       | 356   | 260                         | 260            |
| 26. | Нийт                             |       | 6879          | 4276      | 11155 | 8020                        | 8020           |

/Харьяа ерөнхий боловсролын сургуулийн тоонд үндэслэн вакциныг нэмж татан авалт хийж болно/

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн  
А/80 дугаар тушаалын д/р хавсралт



## САХУУ, ТАТРАНГИЙН ЭСРЭГ ВАКЦИН (TETADIF)-ЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Тодорхойлолт:

Энэ вакцин нь цэвэршүүлсэн сахуу, татрангийн хоргүйсүүр агуулдаг, сахуугийн агууламжийг сулруулж гаргаж авсан.

0.5 мл бүхий 1 хүн тун нь сахуугийн эсрэг дархлал тогтоох чадвар нь 4 олон улсын нэгжээс багагүй, татрангийн эсрэг дархлал тогтоох чадвар нь 40 олон улсын нэгжээс багагүй агуулдаг. Сахуу, татрангийн эсрэг вакциныг хөнгөн цагааны гидроксидийн гелд адсорбцолсон. Тогтворжуулагчаар тиомеросалыг хэрэглэсэн. Вакциныг насанд хүрэгчид болон 7-с дээш насны хүүхдэд сахуу, татрангийн эсрэг идэвхитэй дархлаа тогтоох зорилгоор хэрэглэнэ.

| Найрлага:                                     | Тун                                |
|---|------------------------------------|
| Хэмжээ  | 0.5мл                              |
| Сахуугийн хоргүйсүүр                          | 6Lf/ml (8 ОУН/мл-с багагүй байх)   |
| Татрангийн хоргүйсүүр                         | 20Lf/ml (80 ОУН/мл-с багагүй байх) |
| Хөнгөн цагааны гидроксид (Al <sup>+++</sup> ) | 2.5мг/мл-с ихгүй байх              |
| Тиомеросал                                    | 0.1 мг/мл-с ихгүй байх             |

Вакциныг тарихын өмнө зөөлөн сэгсэрч, нэгэн төрлийн уусмал болсоны дараа бугалганы булчинд тарина. Тарих бүрт нэг удаагийн зүү, тариур хэрэглэнэ.

### Дархлаажуулалтын товлал, бусад вакцинтай харилцан үйлчлэл:

Сахуу, татрангийн эсрэг (Td) вакциныг 7 настайгаас эхлэн эхлэл тунгаар, дархлал сэргээх тунг 15 настайд тарина.

Улаанбурхан, халдварт саа болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин (OPV, IPV), В гепатит, шар чичрэгийн эсрэг вакцинуудтай нэг дор тарьж болно. Мөн витамин А-тай нэг дор хэрэглэж болно.

### Хариу урвал:

Тарьсан хэсэгт улайж, хөндүүрлэнэ. Зарим тохиолдолд халуурч болно. Жирэмсэн хүнд тарихад ямар нэгэн аюулгүй.

### Эсрэг заалт:

Сахуу, татрангийн эсрэг вакцины өмнөх тунг хийлгээд хүнд урвал илэрсэн хүнд дараачийн тунг тарихгүй.

### Дархлаа дутмагшил

Шинж тэмдэг илэрсэн болон илрээгүй ХДХВ, ДОХ-ын халдвартай хүмүүст сахуу, татрангийн эсрэг вакциныг товлолын дагуу тарина.

**Хадгалалт:**

- Сахуу, татрангийн эсрэг вакциныг гэрлээс хол +2 -+8 хэмд хадгалж, тээвэрлэнэ.
- Задалсан вакциныг хэрэглэх журмыг хатуу баримтлан хэрэглэнэ.
- Хөлдөөж болохгүй.
- Вакцин шошгоны монитор 1 ба 2-р шатанд байгаа вакциныг хэрэглэж болох бөгөөд 3 ба 4-р шатанд орсон тохиолдолд хэрэглэхгүй устгана.

**Савлалт:** Флакондоо 10 хүн тунгаар савлагдсан. Хайрцгандаа 10 флакон агуулна.

**Үйлдвэрлэгч:** BB-NCIPD Ltd, Болгар улс

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн  
 А/80 дугаар тушаалын 34 хавсралт



САХУУ ТАТРАНГИЙН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН МЭДЭЭ

| №  | Дархлаажуулалт хийсэн огноо | Нийт             |                      |                | Насаар           |            |                |                  |            |                | ДДУХ |  |
|----|-----------------------------|------------------|----------------------|----------------|------------------|------------|----------------|------------------|------------|----------------|------|--|
|    |                             | Хамрагдвал зохих | Хамрагдсан хүний тоо | Хамралтын хувь | 7 нас            |            |                | 15 нас           |            |                |      |  |
|    |                             |                  |                      |                | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Хамралтын хувь | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Хамралтын хувь |      |  |
| 1  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 2  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 3  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 4  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 5  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 6  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 7  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 8  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 9  |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 10 |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 11 |                             |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |
| 12 | Нийт                        |                  |                      |                |                  |            |                |                  |            |                |      |  |

Мэдээ гаргасан: .....

Мэдээг хянасан: .....

Огноо: .....

Хянасан: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхэлсэн

орлогч дарга

Т.Энх-Амгалан

Боловсруулсан: Тархвар судлаач

Ө.Ариунжаргал